

ТЕГ-ЫН ТУСГАЙ АРХИВД ХАДГАЛАГДАЖ БУЙ МОНГОЛЫН ШАШИН, СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ БАРИМТЫН ТУХАЙ

Б.Эрдэнэбилэг (Ph.D)

ТЕГ-ын тусгай архивын дэд дарга

Түлхүүр үгс: *Шашны хэрэг эрхлэх газар, сүм хийд, лам нарын бүртгэл*

Товч утга: *ТЕГ-ын Тусгай архивд 1930-аад онд нам, төрөөс шашны талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа, сүм хийдийн жас, аж ахуйд холбогдох баримт /767 сүм хийдийн 5953 тооны барилга гэх мэт/ болон 1944 онд нээгдсэн Гандан хийдийн үйл ажиллагаанд холбогдох баримтууд хадгалагдаж байна. Тухайлбал: ДЯЯ-наас шашин, сүм хийдийн талаар явуулж буй ажлын тухай маршал Х.Чойбалсан болон нам, төрийн дээд байгууллагад явуулсан илтгэл мэдээ, Гандан хийдийн хурал номын үйл ажиллагааны тухай, лам нарын бүрэлдэхүүн, хөрөнгө чинээ, жасын аж ахуйн орлого, зарлага, сүсэгтэн олон ба дотоод, гадаадын бусад хүрээ, хийдүүдтэй харилцах харилцааг тодорхойлсон баримтууд нэлээдгүй байна.*

БНМАУ-ын СнЗ-ийн шийдвэрээр 1934 онд хүрээ, хийдийн дэргэд Засгийн газрын тусгай төлөөлөгч суулгах болж үүнээс 3 жилийн дараа 1937 оны 5 дугаар сард СнЗ-ийн 10 дугаар хурлын тогтоолоор хүрээ, хийдийн дэргэдэх Засгийн газрын төлөөлөгчдийг Дотоод явдлын яамны харьяанд шилжүүлж, тус яамны харьяанд Шашны хэрэг эрхлэх газрыг /ШХЭГ/ байгуулсан.

ТЕГ-ын Тусгай архиваас монголын шашин, сүм хийдийн түүхэнд холбогдох баримтуудыг /ШХЭГ-ийн үйл ажиллагаанд холбогдох баримтууд болон бусад/ судалгааны эргэлтэд оруулах тал дээр анхаарч, хэд хэдэн эмхэтгэлийг нийтийн хүртээл болгоод байна. Үүнд: Б.Эрдэнэбилэг “Монголын сүм хийдийн түүхээс” УБ;2012 он, /нэмж эмхэтгэсэн 2 дахь хэвлэлийг 2014 онд сүм хийдийн байрилын зургаар баяжуулж хэвлэсэн/, Д.Буджав “Боржигин Сэцэн вангийн хошууны сүм хийдийн баримтууд” УБ;2019 он, Д.Буджав “Төв аймгийн сүм хийд, лам нарын бүртгэл” УБ;2019 он болно. Цаашид 1931 оны засаг захиргааны зохион байгуулалтаар байгуулагдсан 13 аймгийн сүм хийдийн түүх, лам нарын бүртгэлийг цувралаар эмхэтгэн гаргахаар ажиллаж байна.

* * * * *

ТЕГ-ын Тусгай архивт шашин, сүм хийдийн түүх болон төр, шашны харилцааны түүхэнд холбогдох баримтууд нэлээдгүй хадгалагддаг.

1933 оноос Лхүмбийн хэргээр эхэлж, 1937 онд оргилдоо хүрсэн “их хэлмэгдүүлэлт”-ийн жилүүдэд шашны өндөр цол, хэргэмтэй, нөлөө бүхий томоохон лам нарыг “Ёнзон хамба, дэд хамбын хэрэг”, “Эсэргүү лам нарын хэрэг” зэрэг хэрэгт холбогдуулан хэлмэгдүүлсэн. Нийт 30.000 гаруй хүнийг хэлмэгдүүлснээс 17.000 нь /нийт хэлмэгдэгсдийн 55,7 %/ лам нар байсан. Эдгээр хэлмэгдсэн хүмүүст холбогдох баримт тус архивт хадгалагддаг.

1990 оноос лам нарыг цагаатгах ажил эхэлсэнтэй холбоотойгоор судалгааны эргэлтэд тодорхой хэмжээнд оруулж, Цагаатгалын комиссоос гаргасан хэлмэгдэгсдийн Цагаан ном мөн хувь судлаачдын намтар судлалын бүтээлүүдэд баримтууд нь гарсан.

1930-аад онд Монголд явагдсан хэлмэгдүүлэлт зөвхөн улс төрийн хэлмэгдүүлэлт байсангүй, сүм хийд эзгүйрч, хаягдан монголчуудын соёлын өв болох олон зуун жилээр бүтээн байгуулсан байшин барилга, ард олны нийтээр шүтэн биширч бүтээлгэсэн бурхан тахилын зүйлсийг устгасан соёлын хэлмэгдүүлэлт байв.

Үүнийг баримтад тулгуурлан үзэхэд тухайлбал: ДЯЯ-наас сүм хийдийн устгалын ажлын тухай маршал Х.Чойбалсанд бичсэн илтгэлээс үзэхэд: ДЯЯ-ны харьяа Шашны Хэрэг Эрхлэх Газраас 1938 оны байдлаар 767 сүм хийдийн 5953 тооны барилга байгаа ба дээрх сүм хийдийн 23 нь Өвөрхангай аймагт, Завхан аймагт 32, Булган аймагт 71, Сэлэнгэ аймагт 32, Дорнод аймагт 46, Архангай аймагт 132, Дорноговь аймагт 68, Увс аймагт 11, Төв аймаг болон Улаанбаатар хотод 139, Ховд аймагт 24, Өмнөговь аймагт 59, Хэнтий аймагт 99, Хөвсгөл аймагт 32 сүм хийдийн барилга байна¹ гэж бүртгэн тэмдэглэсэн байдаг.

Эзэнгүй болсон 5461 тооны сүм хийдийн барилгыг 1939 онд хувиарласнаас сургуулийн үйл ажиллагаанд 710, эмнэлэгт 1082, станцад 160, лам нарын нэгтгэлд /гар үйлдвэрт/ 379, худалдааны газарт 1136, цэргийн ангиудад 748, засаг захиргаанд 657, Нам, олон нийтийн байгууллагад 343, Дотоод Явдлын яамны харьяанд 245 тооны барилга хуваарьласан байна.

Улсын хэмжээн дэх бүх хүрээ хийдийн дотроос 37² сүм хийдийн барилга нь уг хувиарлалтад ороогүй. Эдгээр нь албан байгууллагуудаас хол, зам харилцаа муу улмаас, мөн шавар шороогоор үйлдсэн бөгөөд өөрчлөн засаж дахин ашиглах боломжгүй эвдэрч хэмхэрэн ялзарсан байжээ.

Үйл ажиллагаа нь зогсож эзгүйрсэн сүм хийдийн доторхи бурхан тахилын зүйл, ном, үнэт эдлэл, эд хогшил болон элдэв зүйлс, жасын мал зэргийг улсын орлого болгон хураан авчээ. 1939 оны байдлаар бэлнээр нийт 233.847 төг, 5916 кг зэс, гуулин эдлэл, 133 кг 449 гр алт, 1,607 гр / буюу 1 кг 607 гр/ сувд хураан авчээ.

Эдгээр сүм хийдээс хураан авсан зэс, гуулин бурхан зэрэг нийт 71,6 тонн зүйлийг Зөвлөлт Холбоот улсад шилжүүлжээ.³

Мөн хаагдсан хүрээ хийдүүдэд харьяалагдаж байсан 26722 толгой мал буюу адуу 3173, үхэр 1213, тэмээ 1185, хонь 16116, ямаа 5245 толгойг хураан авч адуу 1728, үхэр 881, тэмээ 549, хонь 12984, ямаа 2768 толгой нийт 18910 толгой мал ардуудад олгосон⁴ байна.

ТЕГ-ын Тусгай архивт 1944 онд сэргээсэн Гандан хийдийн үйл ажиллагаанд холбогдох цөөнгүй баримт хадгалагдаж байна.

Тухайлбал: Харин Гандан хийдийн үйл ажиллагааны тухай тус архивт хадгалагдаж буй нэгэн баримтаас тодруулан үзэхэд: “Улаанбаатар хотын Гандан хийдийн 1949 оны жилийн үйл ажиллагааны тухай товч справка”-д:

Гандан хийд нь 1944 оны 6 дугаар сарын 1-нд шинэчлэн нээж явуулснаас хойш 5 жил болсон бөгөөд өөрийн орлогоор зарлагаа нөхөж, эд аж ахуй ба сүм жасын дотоод

¹ ТЕГ-ын ТА. Ф-1. ШХЭГ. хн-438. тал 3

² ТЕГ-ын Тусгай архив. Сан 1, х 2, д /ШХЭГ/, хн-438. тал 4

³ “Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэн товчоон”. УБ. 2001. тал 93

⁴ ТЕГ-ын ТА. Ф-1. ШХЭГ. хн-438. тал 7

хэрэглэлийн талаар нэлээд бэхжиж, сүсэгтэн олон ба дотоод, гадаадын бусад хүрээ, хийдүүдтэй харилцаа нь өргөжсөн байна.

1949 онд Гандан хийд нь:

1. Лам нарын бүрэлдэхүүний хувьд 1949 оны 1 сарын 1-ний байдлаар 56 ламтай байсан бол жилийн хугацаанд лам болохоор хүсэлт гаргасан хүмүүсээс 5 хүнийг нэмэн авч, нийт 61 ламтай болсон бөгөөд үүнээс 2 лам наснаас нөгчиж, 1 лам сахил ёсоо зөрчсөн учир хасагдаж, 1950 оны 1 сарын 1-ний байдлаар 58 ламтай болжээ гээд дээрх 58 ламыг насны байдлаар, хувийн хөрөнгө чинээ, мяндаг тушаалаар нь ангилсан байдаг.

1949 онд Гандан хийдэд Улаанбаатар болон орон нутгаас нийт 20358 хүн хурал хуруулж, биеэр төгрөг 1.112.783, алт, мөнгө, эдлэлийн үнэ төгрөгөөр 598.433, 17375 төгрөгийн мал, бүгд 1.738.592 төгрөгийн орлого оруулсан байна.¹

1950 оны 1 сарын 1-ний байдлаар 1949 оны орлого, зарлагын тооцоог бодоод банкны харилцахад үлдсэн бэлэн мөнгө нь 482.042 төгрөг, 25 мөнгө байжээ.

Мөн дээрх хугацааны байдлаар Гандангийн бүх хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө нь төгрөгөөр тооцоход 1.840.482 байжээ.

Гандан хийд нь хурал номын дотоод үйл ажиллагаанаас гадна улс, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байжээ. Тухайлбал: 1949 онд улсын өртөөнд зориулан адуу 15, тэмээ 15, биеэр 100.000 төгрөг Засгийн газарт, 20.029 төгрөгийг Галын аюулаас хамгаалах байгууллагад тус тус шилжүүлжээ. Мөн тус хийдийн лам нараас сайн дураар 5 ханатай гэр нэгийг улсын өртөөнд шилжүүлжээ.

1950 оны байдлаар тус хийдийн лам нарын цалин нь хамба лам 550 төгрөг, дэд хамба, бага гэвхүй их унзад, нярав нар тус бүр 450 төгрөг, их гэвхүй 525 төгрөг, бага унзад 425 төгрөг, мөнгөний нярав, номын сангийн эрхлэгч нар 400 төгрөг, даамал 500 төгрөг, гарашийн эрхлэгч 410 төгрөг, тахилч 330 төгрөг, дуганч 320 төгрөг, сул лам нар 300 төгрөгийн цалин тус тус авч байжээ.²

Гандан хийд нь орон нутгийн хийдүүдээс гадна гадаадын /өвөрмонголын/ хүрээ, хийдүүдтэй харилцаа холбоо тогтоон ажиллаж байжээ. Тухайлбал: Орон нутгийн Ховд аймаг дахь Вангийн хүрээ, Дорноговь аймгийн Айраг ба Их Хэтийн хурал, Сүхбаатар аймгийн Зотол сумын Хуучдын хурал, Чойбалсан аймгийн Хөлөнбуйр сумын баргын хурал, Хэрлэнбаян-Улаан сумын үзэмчний хурал зэрэг газруудад лам нараа томилон явуулж, хурал номын талаар зааварлах, зааврын биелэлтээ хянах зэргээр ажиллаж байжээ.

Гадаад харилцааны тухайд Улсын 28 жилийн ойг тохиолдуулан Гандан хийдээс Засгийн Газрын дэргэдэх шашин мөргөлийн хэргийг эрхлэх төлөөлөгчийн газар хүсэлт тавьж, Дотоод Монголын зарим хүрээ, хийдийн лам нарыг урьж, Шилийн голын аймгийн Бандид гэгээний хийд, Сөнөд Цагаан-Овооны хийд, Улаанцавын чуулганы Дархан бээлийн хошууны Батхаалгын хийд, Дөрвөд Шар мөрөнгийн хийд зэрэг 5 хийдийн 17 мяндаг, тушаалтай лам нар зочлон ирж байгаад буцсан баримт байна.

БНМАУ-ын СнЗ-ийн шийдвэрээр 1934 онд хүрээ, хийдийн дэргэд Засгийн газрын тусгай төлөөлөгч суулгах болж үүнээс 3 жилийн дараа 1937 оны 5 дугаар сард СнЗ-ийн 10 дугаар хурлын тогтоолоор хүрээ, хийдийн дэргэдэх ЗГ-ын төлөөлөгчдийг ДЯЯ-ны

¹ Мөн нэгж. т 5

² Мөн нэгж. т 12-13

харьяанд шилжүүлж, тус яамны харьяанд Шашны хэрэг эрхлэх газрыг /ШХЭГ/ байгуулсан.

ТЕГ-ын Тусгай архивт хадгалагдаж буй ШХЭГ-ын хөмрөгийн баримтыг судалгааны эргэлтэд оруулах тал дээр анхаарч, Гандантэгчэнлин хийдийн Эрдэм, соёлын хүрээлэнтэй хамтран хэд хэдэн эмхтгэлийг нийтийн хүртээл болгоод байна. Үүнд: “Монголын сүм хийдийн түүхээс” УБ;2012, /нэмж эмхэтгэсэн 2 дахь хэвлэлийг 2014 онд сүм хийдийн байршлын зургаар баяжуулж хэвлэсэн/, “Боржигин Сэцэн вангийн хошууны сүм хийдийн баримтууд” УБ;2019, “Төв аймгийн сүм хийд, лам нарын бүртгэл” УБ;2019 он, “Дорноговь аймгийн сүм хийдийн баримтууд” УБ.,2020, “Булган аймгийн сүм хийд, лам нарын баримтууд” УБ.,2020 зэрэг 10 гаруй бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн.

НОМ ЗҮЙ

1. ТЕГ-ын ТА. Ф-1. ШХЭГ. хн-438. тал 3
2. ТЕГ-ын Тусгай архив. Сан 1, х 2, д /ШХЭГ/, хн-438. тал 4
3. “Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэн товчоон”. УБ. 2001. тал 93
4. ТЕГ-ын ТА. Ф-1. ШХЭГ. хн-438. тал 7

ABSTRACT

The documents relating to the policy, activities toward religious institution implemented by the Mongolian government and political party in the 1930's, accounts of monastery treasury, property and economics (including 5953 buildings of 767 temples and monasteries) and reports relating to the activities of the Gandan monastery, which was opened in 1944 kept in the Special Archives of the General Intelligence Agency of Mongolia.

For example, report of the activities on religion, temple and monasteries executed by Ministry of Internal Affairs sent to Marshal Kh. Choibalsan, political party and state organizations, information of the activities of the Gandan monastery, the composition of monks, wealth of the monks, many documents that describe the income and spending of monasteries, relationship between laypeople and monasteries, cooperation between local and foreign monasteries reserved in the special archives of GIA.

In 1934, the Council of Ministers of People's Republic of Mongolia sent a special state representative in the monastery compounds in 1934 and three years later, in May 1937, by the Decree of the Council of Ministers, the state representatives of the monastery were transferred to the Ministry of Internal Affairs and established the Religious Affairs Agency in the the Ministry of Internal Affairs.

The Special Archives of the GIA pay attention to bring those archive documents into research circles. The Special Archives of the GIA has been publishing several publications in relation to the history of Mongolian religions and monasteries (including documents related to the Religious Affairs Agency and others). For example B.Erdenebileg, “The History of Mongolian Monastery” UB; 2012, 2nd Edition, compiled by the map of the monasteries in 2014), D.Budjav “The Documents of the Monasteries of Borjigin Setsen Khan” Ulaanbaatar, 2019, D.Budjav “The registration of the monasteries and lamas of Tuv aimag “ UB 2019. In the future, we are working to compile the history of monasteries and the registration of monks in 13 aimags established in 1931 administration structure.